



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 12 сарын 21 өдөр

Дугаар А/668

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189 дүгээр зүйлийн 189.5 Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3 тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас ирүүлсэн хүсэлтийг шийдвэрлэх хүрээнд хорихоос өөр төрлийн ял албадлагын арга хэмжээ авагдсан ялтан этгээдүүд, хоригдол, хоригдогсдыг нийгэмшүүлэх ажлын хүрээнд сургалтын орчин нөхцөлийг сайжруулах, сургалтын танхим засварлах зардалд 9.000.000 (есөн сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардлын 9.000.000 (есөн сая) төгрөгийг аймгийн Засаг дарга дансны мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Э.Улам-Өсөх)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

